



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 540

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын
хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Дээд шүүхийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 55,581,000.00 /тавин таван сая таван зуун наян нэгэн мянга/ төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн цаашид ашиглаж болох автомашины ашиглах хугацааг сунгаж, үнийг 25,000,000.00 /хорин таван сая/ төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн Тамгын газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын Дээд шүүхийн тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Амардэлгэр, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн Тамгын газрын дарга Л.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг хүлээлцэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн
540 дугаар тогтоолын хавсралт

Улсын Дээд шүүхийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэх өртөггүй ашиглах хугацааг
сунгаж, үнийг шинэчлэн тогтоон Замын-Үүд сумын сум дундын шүүхийн тамгын газарт
балансаас балансад шилжүүлэх автомашин

№	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтанд орсон он	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	Ланд круйзер-100 улсын дугаар 26-00 УБЕ, арлын дугаар JTECJ09JX05509548	2004/2004	55,581,000.00	25,000,000.00	3
2	Нийт дүн		/Тавин таван сая таван зуун наян нэгэн мянган төгрөг/	/Хорин таван сая төгрөг/	